

ДеФакто **ТОЙМ**

➤ "АЗИЙН ТӨЛӨӨХ
БОАО ФОРУМ" –ААР
ЮУ ЯРИВ?

➤ МАХНЫ ҮНЭ
ЭКСПОРТТОЙ
ХОЛБООТОЙ ЮУ?

VI НҮҮРТ



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

НАМУУД ТӨЛӨВШИЖ БАЙНА УУ?

II НҮҮРТ



Францын батлан хамгаалах яамны дэргэдэх
"Батлан хамгаалах сургуулийн стратеги
судлалын институт" (IRSEM) –ын захирал
Jean-Baptiste Jeangène Vilmer-тэй ярилцав.

Мэдээллийг гүйвүүлэх
ГУРВАН АЛХАМТ ГЭЖ ЮУ ВЭ?

IV НҮҮРТ

WEEKLY

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.08.29, №8 (112)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

УЛС ТӨРИЙН НАМЫН ДОТООД
**АРДЧИЛЛЫН
ИНДЕКС-2019**

The cover features a grid of national emblems and logos of political parties from various countries, including Mongolia, Malaysia, and others. The background is a dark green with a faint image of a classical building.



Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

НАМУУД ТӨЛӨВШИЖ БАЙНА УУ?

30 жилийн өмнө монголд улс төрийн ганцхан нам байлаа. Тэгвэл 2018 онд 29, жилийн дараа 33 намтай болжээ. Намууд сонгуульд өрсөлдөх, ялвал төр засгийн эрхийг авахаас гадна нийтийн улс төрийн боловсролыг дээшлүүлж, сонгуулийн бус үеэр ч иргэдийн дуу хоолой болж, үзэл бодлыг нь илэрхийлэх, төлөөлөх үүрэгтэй. Манай улс төрийн намуудын тоо нь өссөн ч чанар, төлөвшил хангалтгүй хэвээрээ, нийтийг нэгтгэж төлөөлдөг гэхээсээ илүү *хаалттай клуб* байсаар байна.

Хараат бус, судалгааны Дефакто Институт өнгөрсөн оноос намуудын нээлттэй, ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, дотроос нь гишүүд нь, гаднаас нь олон нийтийн хяналт, шахалтыг нэмэгдүүлэх зорилгоор “Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс”-ийг гаргаж эхэлсэн. Хоёр дахь судалгааг энэ оны 4-6 дугаар саруудад явуулав.

Намуудын дотоод ардчиллын индекс нь намуудыг оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, ил тод байдал-санхүүжилт гэсэн дөрвөн бүлэг үзүүлэлтээр хэмжиж 0-100 оноогоор үнэлдэг. Үүнээс 0-30 оноо авсан бол ардчилалгүй, 31-60 оноо авбал хагас ардчилсан, 61-100 оноо авбал ардчилсан гэж ангилдаг.

Өнгөрсөн оны судалгаанд Ардчилсан Нам- АН, Монгол Ардын Нам- МАН, Монгол Ардын Хувьсгалт

Нам-МАХН, Хөдөлмөрийн Үндэсний Нам-ХҮН, Иргэний Зориг Ногоон Нам-ИЗНН, Эх Орон Нам- ЭОН гэсэн зургаан нам оролцож байсан бол, 2019 онд Монголын Ногоон Нам-МНН, Үнэн ба Зөв Нам-ҮЗН нэмэгдэж найм болов. Бусад намууд холбогдох боломжгүй, бусад нь судалгаанд оролцохоос цааргалж, эсвэл татгалзав.

Өнгөрсөн жил тоон судалгааг намын гишүүдтэй утсаар холбогдож асуулгаар, чанарын судалгааг экспертүүдтэй ярилцаж гаргасан. Энэ жилийн хувьд судалгааны аргачлал, арга зүйгээ боловсронгуй болгож, чанарын судалгааны аргыг ашиглав.

Хүснэгт 1. Намуудын дотоод ардчиллын индекс 2019

| № | Улс төрийн нам | Индекс | Ангилал |
|---|----------------------------|--------|-----------------|
| 1 | Монголын Ногоон Нам | 66 | Ардчилсан |
| 2 | Монгол Ардын Хувьсгалт Нам | 66 | Ардчилсан |
| 3 | Ардчилсан Нам | 65 | Ардчилсан |
| 4 | Хөдөлмөрийн Үндэсний Нам | 63 | Ардчилсан |
| 5 | Монгол Ардын Нам | 55 | Хагас ардчилсан |
| 6 | Эх Орон Нам | 47 | Хагас ардчилсан |
| 7 | Үнэн ба Зөв Нам | 42 | Хагас ардчилсан |
| 8 | Иргэний Зориг Ногоон Нам | 32 | Хагас ардчилсан |

НАМ БОЛ КЛУБ БИШ

Судалгааны баг намуудын үндсэн дүрмийг хайлаа. МАН, АН, МАХН, МНН зэрэг намууд дүрмээ цахим хуудсандаа байрлуулжээ. ХҮН дүрмээ хүсэлтийн дагуу явуулсан бол, ҮЗН бусад нам хуулбарлана гээд явуулсангүй.

Судалгааны баг улмаар намуудыг бүртгэдэг Улсын Дээд Шүүхэд хүсэлт явуулсан. Гэвч Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12.5-ын дагуу хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээллийг гаргахад тухайн этгээд бичгээр зөвшөөрсөн байх шаардлагатай гээд бас өгсөнгүй. Ардчилал хөгжсөн орнуудад намууд болон олон нийтийн байгууллагын талаар иргэдийнхээ мэдэх эрхийг баталгаажуулдаг. Тухайлбал Германы

улс төрийн намын тухай хуулийн 6.3-т: “намын үндсэн дүрэм, мөрийн хөтөлбөр, намын төлөөллийн төв байгууллага болон орон нутгийн нэгжийн шийдвэр гаргах албан тушаалтнуудын нэр, үүргийн талаарх мэдээлэл, түүний хуулбарыг нийтэд үнэ төлбөргүй олгоно” гэжээ.


Улс төрийн нам нь үйл ажиллагаанаасаа эхлээд дүрэм, журам, санхүүжилт нь хүртэл иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй байх ёстой олон нийтийн байгууллага. Наад зах нь, дүрмээ албан ёсны вебсайт, нийгмийн сүлжээний хаягаар нь уншиж болохоор байрлуулах ёстой. ►►

▶ ЮУ ӨӨРЧЛӨГДСӨН БЭ?

Энэ жил УИХ-ын 42-р тойргийн нөхөн сонгуульд бэлтгэх, нэр дэвшигчээ тодруулах зорилгоор улс төрийн намуудын гишүүдийн оролцоо бүх түвшинд идэвхжсэн байлаа. Мөн УИХ-ын ээлжит сонгуулийн өмнөх жил гэдгээр онцлог байв. Намууд их, бага хурлаа хийж гишүүдийн оролцоо харьцангуй нэмэгджээ.

Өнгөрсөн жил судалгаанд оролцсон 6 намын хувьд тодорхой өөрчлөлт гарсныг доор харуулав. Дөрвөн намын дотоод ардчилал сайжирсан бол хоёр намынх (ЭОН, ИЗНН) суларсан байна.

Хүснэгт 2: 2018 ба 2019 оны индексийн харьцуулалт




Судалгааны бүлэг тус бүрээр онцолбол, гишүүдийн оролцооны хувьд намууд дотроо бодлогын мэтгэлцээн хийх талаар сул байна. Намынхаа дотоод асуудлыг хэлэлцдэг хэлбэрүүд олон буй ч намын бодлогыг тодорхойлохдоо гишүүд, дэмжигчдийг оролцуулах нь бага байгаа нь бүх намуудад нийтлэг ажиглагдав.

Намын дотоод өрсөлдөөний хувьд 2019 онд УИХ-д олонх, цөөнх болсон МАН, АН-д дотоод ардчиллын муу жишиг гэж хэлж болох тохиолдлууд гарлаа. Хоёр нам зарим гишүүдээ намын нэгдмэл байр сууринаас зөрсөн шалтгаанаар намаас нь гаргав. УИХ-ын гишүүн Ж.Батзанданг намын гишүүнээс нь түдгэлзүүлж, АН УИХ-д намын бүлэггүй хүртэл болов. Харин МАН намын нэгдмэл байр суурь, намын шийдвэрийг зөрчин хотын даргад нэрээ дэвшүүлсэн НИТХ-ын төлөөлөгч С.Мөнхчулууныг намаас нь түдгэлзүүлэв. Намын улс төрийн зөвлөл эсвэл удирдах зөвлөл нэрээр цөөн хэдэн хүн хэн, ямар албан тушаалд очихыг шийддэг болжээ.

Улс төрийн нам нь нийгмийн бүх хэсгийн төлөөллийг хангадаг байх ёстой. Намууд хэдийгээр залуучууд, ахмад, эмэгтэйчүүдийн зэрэг дотоод төлөөллийн байгууллагуудтай ч, УИХ-д төдийгүй намын шийдвэр гаргах албан тушаалуудад эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх нь хангалтгүй байна. Гэтэл сонгуулийн хуулиар нэр дэвшигчдийн 20 хувь нь эмэгтэйчүүд байхыг шаарддаг. Зарим нам дүрмэндээ эмэгтэйчүүдийн квотыг нэмж тогтоосон ч, амьдрал дээр хэрэгжүүлдэггүй ажээ.

Хүснэгт 3. Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс 2019, бүлгээр



Улс төрийн намын тухай хуулиар намууд санхүүгийн үйл ажиллагаандаа хөндлөнгийн хяналт хийлгэж олон нийтэд тайлагнах ёстой. Энэ хуулийг зөвхөн ХҮН, МНН хоёр хэрэгжүүлж нийтэд ил тод, нээлттэй байдлаараа сайн жишиг тогтоож байна. Энэ хоёр нам цахим хуудас, нийгмийн сүлжээний хаяг дээрээ санхүүгийн тайлангаа аудит хийлгэн байршуулжээ. Бусад намуудын хувьд ил тод, нээлттэй байхыг зөвхөн намын гишүүдэд хамаарах, дотоод хүрээний асуудал гэж үзэх хандлага түгээмэл байна.

Өнгөрсөн жил намууд бүгд хагас ардчилсан ангилалд байсан бол энэ жил МНН, МАХН, АН, ХҮН зэрэг намууд ардчилсан ангилалд шилжээд байна. Гэхдээ судалгааны бүлэг тус бүр дээр намуудын оноо харилцан адилгүй байгааг анхаарах хэрэгтэй.

Монголын улс төрийн намууд төлөвших шаардлагатай байна.

Мэдээллийг гуйвуулах ГУРВАН АЛХАМТ ГЭЖ ЮУ ВЭ?

Би таны 10 хоногийн сургалтанд сууснаар, цахим хамгаалалт нь маш чухал гэдгийг ойлгосон. Монгол улс 3,2 сая хүнтэй, 2 том гүрэнтэй хиллэдэг учир технологи бидэнд ихээхэн дэмжлэг болох нь гарцаагүй. Гэхдээ таны хэлсэнчлэн эдгээр технологиудад өндөр хамгаалалт хэрэгтэй гэж үзэж байна. Тухайлбал сонгуулийн үеэр троллууд, хуурамч мэдээ, хуурамч цахим хаягууд гэх мэт зүйлс ихээр гарч ирдэг. Сонгуулийн үеэр болдог эдгээр асуудлууд нь улс болгонд нийтлэг байдал байна уу, эсвэл улс орнуудад өөр байна уу?

Тухайн цаг үеэс хамааран сонгууль болгон ондоо болдог ч сүүлийн жилүүдэд сонгуулиудад ижил төстэй байдал үүсч байна. Хамгийн түгээмэл ажиглагдаж байгаа зүйл нь мэдээллийг гуйвуулах гурван алхамт юм.

1. Эхний алхам бол буруу мэдээг түгээх буюу нэр хүндийг нь гутаах, томоохон медиа вебсайтуудыг ашиглан бай болгосон гишүүдийн талаар худал мэдээ тараах.
2. Хоёрдугаар алхам бол хакердах. Хэрэв боломжтой бол тухайн гишүүний цахим хаягууд руу шууд нэвтрэх эсвэл түүний нарийн бичиг, нягтлан гэх мэт удирдлагад нь ажилладаг хүмүүсийн имэйл хаяг руу нь нэвтрэх доторх мэдээллүүдийг хулгайлах.
3. Гуравдугаар алхам бол хулгайлсан мэдээллээ тараах. Францын хувьд сонгууль болохоос 2 хоногийн өмнө буюу хамгийн сүүлд мэдээллүүдийг тарааж байсан учир гишүүд тухайн мэдээлэлд хариу үйлдэл үзүүлэхэд хэт оройтсон байсан.

Тэгэхээр мэдээллийг гуйвуулах гурван алхамт нь буруу мэдээлэл, хакердах, тараах гэсэн хэсгүүдээс бүрдэж байна. Гэхдээ зарим тохиолдолд 2 болон 3 дахь үе шатны дунд завсрын үе гардаг ба үүнийг бид гуйвуулах гэж нэрлэдэг. Хэрэв тэдний хулгайлсан мэдээлэл дотор ямар нэгэн эдийн засгийн, болон хувийн мэдээлэл, хүчирхийлэлтэй хамаатай мэдээлэл олдоогүй бол худал имэйл хаягуудыг дурдаж жинхэнэ харагдах мэт хуурамч имэйлүүдийг өөрсдөө зохиож эхэлдэг. Энэ нь мэдээллийг илүү хөнөөлтэй болгож эхэлдэг. Мөн эдгээрээс өөр олон арга байдгийг дурдах нь зүйтэй байх.

Таны хэлсэн эдгээр гурван алхамт дайралтанд өртөөл хэрхэн тэмцэж, хамгаалах вэ?

- ♦ Урт хугацааны хамгаалалт нь иргэдэд мэдлэг олгох. Үүнд медиагаар явж буй мэдээллүүдийн аль нь үнэн, аль нь худал болохыг тогтоох чадварыг олгох; ямар нотлох баримтууд үүнийг бодит мэдээ болгож байна зэргийг сургах арга юм. Энэ аргын үр дүн нь 5-15 жилийн гарна.
- ♦ Богино хугацааны хамгаалалт бол институтуудыг байгуулах юм. Жишээ нь бид сонгуулийн үеэр оролцогчдын тэгш байдлыг хангах үүрэгтэй тусдаа сонгуулийн хороо үүсгэж байсан. Мэдээлэл цацагдсан орой хороо маш хурдан хариу үйлдэл үзүүлж маргааш өглөө нь хэвлэлийн бага хурал зарлаж бүх медиа агентуудад тухайн мэдээллүүдийг цацахгүй байхыг анхааруулж, тухайн мэдээлэл нь сэжигтэй байгаа талаар хэлж, бидэнд шалгахад хугацаа хэрэгтэй байгааг анхааруулж байсан. Хэвлэл мэдээллийн байгууллагууд ч үүнийг

дагаж, өчигдөр шөнө тухайн мэдээ цацагдсан гэж зарласан ч энэ нь үнэн гэдгийг зарлаагүй байсан. Ингэснээр өнөөх хар PR сонгуульд оролцогчдод ямар нэгэн хохирол учруулаагүй. Сонгуулийн хороо нь аль аль талдаа төвийг баримтлах ёстой байдаг ч АНУ-ын сонгуулийн үеэр сонгуулийн хороо Хиллари Клинтонг ялна гэдэгт итгэлтэй байсан учир түүний талаар хар мэдээлэл тарахад хариу үйлдэл үзүүлээгүй. Сонгуулийн хороо нь Засгийн газраас сонгогддог ба Засгийн газар ямар нэг талыг барьж байгаа нь тодорхой байдаг. Харин одоо тэд үүнийг өөрчлөх арга замыг хайж байгаа. Мөн Канад улсын элчин сайд энэ оны нэгдүгээр сард хийсэн ярилцлагадаа энэ асуудалтай тэмцэхээр гарц хайж байгаа гэдгээ дурдсан.

Тэгэхээр хүмүүсийн цаг, завьг буруу мэдээлэлд үрэхгүй байх аргыг хэлээч, таны дурдсанаар хамгийн гол нь боловсрол, хоёрт хувийн хороо, байгууллага үүсгэх харин гуравт юу байх вэ?

Иргэний нийгэмтэй байх нь хуурамч мэдээллээс зайлсхийх хамгийн чухал суурь. Түүнээс аль нэгэн төрийн байгууллагаас үзүүлэх хариу үйлдэл биш юм. Яагаад гэвэл төр ихэнх иргэдэд эсрэг тал нь мэт харагддаг, тиймээс иргэд өөрсдийн гэсэн бие даасан арга хэрэгсэлтэй байх хэрэгтэй байдаг.

Бигний тулгарч буй асуудал бол мэдээллийн гайн биш харин өгүүлэхүйн гайн юм. Хэдийгээр бидэнд фактууг байлаа ч гэсэн хангалттай биш. Яагаад гэвэл бусад зөвлөгч илтгэгчдэд тараах цуурхал бэлэн байж л байдаг. Тэгэхээр энэ нь фактын эсрэг цуурхал гэсэн маргааныг гаргаж ирж байгаа юм. Фактуудыг дурдах нь заримдаа чухал биш байдаг учир нь зарим хүмүүст бодит фактаас илүү сэтгэл хөдөлгөсөн цуурхал нь сонирхолтой байдаг. Тиймээс бид фактуудыг сонирхолтой байдлаар өгүүлэх хэрэгтэй болж байгаа юм.

Тиймээс зарим жүжигчид тодруулбал, АНУ-ын "Атлантик Коунсэл" ДФР гэх нэртэй жижигхэн хэмжээний баг бүрдүүлж, буруу ташаа мэдээллийн талаар судлаж байна. Жишээлбэл тэд твиттер дээр байгаа сэжигтэй аккаунтуудыг ашиглан хэн ямар зорилгоор хаанаас хуурамч мэдээг цацаж байгаа талаар, мөн тэдгээр нь ямар нэгэн улс оронтой холбоотой эсэхийг жүжигчлэн дүрсэлдэг. Тэдгээр дүрслэлүүд нь аймшгийн кинотой төстэй харагддаг, яг л гэмт хэрэгтний түүхтэй адилаар хэн үүний ард нуугдаж байгааг харуулдаг. Иргэд фактуудаас илүү энэхүү жүжигчилсэн сонирхолтой төрлийн контентэд илүү дуртай байдаг.

Тэгэхээр Британид болсон сонгуулийн үеэр Оросууд ямар нэгэн аргаар хөндлөнгөөс оролцсон гэх нь үнэн үү?

Тиймээ, энэ үнэн. Нэг нь тусгай албаны ажилтан байсан ба нөгөөх нь Физикч байсан. Гэхдээ бид зөвхөн Орос ч юм уу ганц нэг улс дээр төвлөрөх шаардлагагүй. Харин үүнээс сэргийлж, тэмцэх ямар арга зам байна гэдэгт төвлөрөх хэрэгтэй.

Та бид хоёрын ярилцсан шиг ийм асуудалтай ард түмэн ардчилсан нийгэмд амьдарч байгаа гэсэн утгаараа хэрхэн тэмцэх мөн Засгийн газрын анхаарлыг яаж татах вэ?

Гайхалтай асуулт байна. Энэ мэдээж орон болгонд тулгамдаж буй асуудал. Тиймээс бид энэ асуудлыг хэлэлцдэг уулзалтуудыг нэмэх, шинийг санаачлах хэрэгтэй. Бидэнд энэ асуудлаар уулзаж болох олон газар байгаа, үүний нэг нь Натострат төв. Натостратынхан жил бүр Стратком гэх үйл ажиллагаа зохион байгуулдаг. Эхний жилүүдэд зөвхөн барууны орныхон тухайн үйл ажиллагаанд ирж Европ болон АНУ-ын талаар ярилцдаг байсан. Харин сүүлийн хоёр гурван жилд Азиас олон төлөөлөгчид ирдэг болсон. Мөн сүүлийн үед зөвхөн Натострат ч биш Сингапур, Праг зэрэг хотуудад тухайн уулзалтууд зохиогдож байгаа. Сингапурын уулзалтыг зохиодог "RSIS" байгууллага нь энэ зун гурав дахь жилдээ энэхүү уулзалтыг зохиох гэж байгаа. Барууны болон зүүний улсууд уулзсанаар магадгүй Оросуудын баруунд явуулж байгаа үйл ажиллагаа нь зүүний орнуудаас ямар ялгаатай байна гэх мэт харьцуулалтыг хийх боломжтой болно.



ДеФакто ТОЙМ

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.08.25-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

"АЗИЙН ТӨЛӨӨХ БОАО ФОРУМ" – ААР ЮУ ЯРИВ?

Үйл явдлын товч:

Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд Азийн төлөөх Боао форумыг Улаанбаатарт зохион байгуулсан. Монгол Улс нь Азийн эдийн засаг, хөгжлийн асуудлыг хэлэлцдэг чухал суваг болох Азийн төлөөх Боао форумыг санаачлагч орнуудын нэг. Монгол Улсад зохион байгуулж буй форумын анхны арга хэмжээ болох Улаанбаатарын Бага хурал 8-р сарын 20-нд болсон. Бага хурлын үйл ажиллагаанд Монгол, Хятад, Өмнөд Солонгос, Пакистан зэрэг 10 гаруй орны 300 орчим Засгийн газрын болон хувийн хэвшлийн төлөөлөл оролцсон.

Дүгнэлт тайлбар:

Давосын дэлхийн эдийн засгийн форумын жишгээр Азийн эдийн засаг, хөгжлийн асуудлыг хэлэлцэх форум байгуулах санаачилгыг 1990-ээд оны сүүлээс Азийн нөлөө бүхий улс төрчид дэвшүүлсэн. Манай улс зэрэг Азийн 26 орон уг санаачилгыг дэмжсэнээр Азийн төлөөх Боао форумыг 2001 онд байгуулсан. Боао форумын төв БНХАУ-ын Хайнань мужийн Боаод байрладаг. Жилийн уулзалт зэрэг гол үйл ажиллагаа Боаод болдог. Гэхдээ сүүлийн жилүүдэд үйл ажиллагааны хэлбэр, хүрээ нь тэлж буйтай холбоотойгоор Азийн орнууд төдийгүй бусад оронд зохион байгуулдаг болж байгаа. Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд форумыг манай улсад зохион байгуулах санаачлагыг дэмжсэн. 2002 оноос хойш жил бүр зохиож буй форумын жил бүрийн уулзалтад манай төр, засгийн удирдлага тогтмол, идэвхтэй оролцож ирсэн. Хамгийн сүүлд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2018 оны уулзалтад оролцож үг хэлсэн. Азийн эдийн засгийн асуудлаар төр, засгийн албаны хүмүүс, эрдэмтэн судлаачид, бизнес эрхлэгчдийн түвшинд санал бодлоо чөлөөтэй солилцдог.

“Шинэ эрин үе дэх хамтын хөгжил дэвшлийн төлөөх уялдаатай үйл ажиллагаа” гэсэн ерөнхий сэдвийн дор явагдсан Улаанбаатарын бага хурлын үеэр “Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин, бизнесийн боломжууд”, “Хөгжлийн зам” хөтөлбөрийг “Бүс ба Зам” санаачилгатай уялдуулан хэрэгжүүлэх нь”, “Дэд бүтцийн харилцан холбогдох байдлыг бүс нутгийн хүрээнд өргөжүүлэх нь”, “Ногоон хөгжлийг хамтын зорилт болгох нь” гэсэн сэдвээр хэлэлцүүлэг болсон.



Боао форумын дарга Бан Ги Мүн:

Дэлхийн эдийн засгийн хямрал эхэлснээс хойш яг 10 жилийн дараа, дахин нэг уулзвар дээр ирээд байна. Даяаршлаас гэнэт огцом ухарч, популизм, протекционизм өсөн нэмэгдсэнийг гэрчилж буй энэ үед, дэлхий даяар засаглалд бэрхшээл тулгарч байна. Нэг талыг баримталсан зарчим нь дэлхийн эдийн засгийн өсөлтөд дарамт шахалт үзүүлсэн бол, худалдааны протекционизм нь чөлөөт худалдааны олон талт тогтолцоог сүйтгэж байна. Үүнээс гадна цөмийн аюулгүй байдал, геополитикийн мөргөлдөөн, террорист халдлага, дүрвэгсдийн шилжилт хөдөлгөөн зэрэг асуудлыг хараахан үр дүнтэй шийдвэрлэж, хяналтаа тогтоож чадаагүй байна. Эдийн засаг нь шинэчлэгдэн хөгжиж буй орнууд дотоод тэнцвэргүй байдал, гадаад цочролд өртөмтгий байдаг. Азийн эдийн засгийн өсөлт 2018 онд 6.5 хувь байснаас 2019 онд 6.3 хувь, 2020 онд 6.4 хувь болж буурна. Уур амьсгалын өөрчлөлт, хүн амын насжилт, дижитал цахим хуваагдал зэрэг уламжлалт бус сорилтууд нь ази, дэлхийн эдийн засгийн ирээдүйг эрс өөрчилж болзошгүй юм. Уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалсан олон улс, бүс нутаг дахь сорилтуудыг хөндөж, Зүүн хойд Азийн Цэвэр агаарын түншлэл (NEACAP), өөрийн тэргүүлдэг Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага (GGGI) зэрэг механизмуудын хүрээнд Монгол Улстай агаарын бохирдлыг бууруулах, ногоон хөгжлийг дэмжих чиглэлээр хамтран ажиллах боломжтойг хэлсэн.

МАХНЫ ҮНЭ ЭКСПОРТТОЙ ХОЛБООТОЙ ЮУ?

Үйл явдлын товч:

66 сая малтай байж нэг кг махыг 14-16 мянган төгрөгөөр худалдан авч байна гэж олон нийт маш бухимдалтай байгаа. Өнгөрч байгаа долоо хоногт болсон улсын онцгой комиссын хуралдаан дээр Ерөнхий сайд Ч.Улаан сайдад махны үнэ өсвөл та толгойгоороо хариуцна шүү гэж хэлсэн.

| Баг, хороо | Малын төрөл | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|------------|-------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| Улсын дүн | Бүгд | 51,982.58 | 55,979.78 | 61,549.24 | 66,218.96 | 66,460.18 |
| | Адуу | 2,995.75 | 3,295.34 | 3,635.49 | 3,939.81 | 3,940.09 |
| | Үхэр | 3,413.85 | 3,780.4 | 4,080.94 | 4,388.46 | 4,380.88 |
| | Тэмээ | 349.3 | 367.99 | 401.35 | 434.1 | 459.7 |
| | Хонь | 23,214.78 | 24,943.13 | 27,856.6 | 30,109.89 | 30,554.8 |
| | Ямаа | 22,008.9 | 23,592.92 | 25,574.86 | 27,346.71 | 27,124.7 |

Хэмжих нэгж: мян.тол

* Үндэсний статистикийн хороо

Дүгнэлт тайлбар:

Хүнсний захуудад зарагдаж байгаа үхрийн мах нэг кг нь 6 доллар орчим байгаа.

Сүүлийн 5 жилийн статистикаар жилд 10-12 сая толгой малыг мал аж ахуйгаас хүнсэнд нийлүүлсэн байна. Хүнсэнд бэлтгэсэн малын тоог нийт малын тоонд харьцуулснаар хонь 23%-ийг, ямаа 21%-ийг, үхэр 16%-ийг, адуу 10%-ийг, тэмээ 7%-ийг тус тус эзлэж байна. Хөдөө аж ахуйгаас бэлтгэсэн махны 10 орчим хувийг л үйлдвэрийн аргаар бэлтгэдэг. Энэ нь дэлхий дахинд хориотой. Ямар орчинд, хэрхэн ариун цэврийн шаардлагыг хангаж мах бэлтгэсэн бэ гэдэг чухал асуудал.

Хэдийгээр үхрийн махны экспорт 2015 оноос хойш буурч байгаад 2018 онд нэмэгдсэн байгаа ч экспортын 90 орчим хувийг зөвхөн адууны мах эзэлж байна.

| Статистик үзүүлэлт | Гол нэр төрлийн бараа | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|------------------------|------------------------|---------|---------|-----------|-----------|----------|
| Тоо хэмжээ | Үхрийн хөлдүү мах (тн) | | 847.65 | 695.09 | 600.13 | 1,114.1 |
| | Адууны мах (тн) | 1,822.2 | 3,856.9 | 7,983.6 | 26,118.71 | 32,200.8 |
| Үнийн дүн(мян.ам.долл) | Үхрийн хөлдүү мах (тн) | | 2,621.9 | 1,592.29 | 1,644.07 | 3,306.1 |
| | Адууны мах (тн) | 4,971.5 | 7,318.5 | 14,392.62 | 44,529.23 | 64,974 |

Хэмжих нэгж: мян.ам.долл

* Үндэсний статистикийн хороо

Улсын хэмжээнд нийт 123 мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, цех байна. Эдгээрээс Улаанбаатар хотод 79, хөдөө орон нутагт 44 үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байна. Давхардсан тоогоор эдгээрээс 8 нь ангилсан мах, 115 нь дулааны аргын боловсруулсан махан бүтээгдэхүүн (хиам, нөөшилсөн мах) үйлдвэрлэдэг бөгөөд тус үйлдвэрүүдийн нийт суурилагдсан хүчин чадал хоногт 128 тонн.

2017 оны 12 сарын байдлаар БНХАУ-д адууны мах экспортлох эрхтэй 8 аж ахуйн нэгж, хонь ямаа, үхрийн мах экспортлох эрхтэй 6 аж ахуйн нэгж, дулааны аргаар боловсруулсан мах экспортлох эрхтэй 5 аж ахуйн нэгж, нядалгааны эрхтэй 8 аж ахуйн нэгж ОХУ улсад мах махан бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий магадлан итгэмжлэгдсэн 29 аж ахуйн нэгж, Вьетнам улсад дулааны аргаар боловсруулсан хонь, ямаа, үхрийн мах экспортлох эрх бүхий магадлан итгэмжлэгдсэн 4 аж ахуйн нэгж тус тус байна.



中华人民共和国国家认证认可监督管理局
Certification and Accreditation Administration of the People's Republic of China

蒙古国肉类生产企业在华注册名单 (2018年3月26日更新)

| 冷冻牛肉加工企业在中国注册名单 (6家) Frozen Beef and Mutton Establishments (6) | | | | | | |
|---|---------|--|--|---|--|----|
| 序号 | 注册号 | 企业名称 | 企业地址 | 生产方式 | 注册品种* | 备注 |
| 1 | 5342074 | Green grassland | Green grassland Mon-Tiva Factory,Ubs Province | 屠宰、分割、储藏 Slaughter, Cutting, Storing | 冷冻山羊肉、冷冻绵羊肉、冷冻牛肉 Frozen goat meat, Frozen mutton, Frozen beef | |
| 2 | 4138945 | Mongol Eco Meat Hovsgol Makh Market Co., Ltd | 1-23B, 3th Bag, Muran, Hovsgol Province, Mongolia | 屠宰、分割、储藏 Slaughter, Cutting, Storing | 冷冻山羊肉、冷冻绵羊肉、冷冻牛肉 Frozen goat meat, Frozen mutton, Frozen beef | |
| 3 | 5394104 | ZAVKHAN KHUNS GROUP | Industry section, Ulzai bag, Ulaistai soum, Zavkhan province, Mongolia | 屠宰、分割、储藏 Slaughter, Cutting, Storing | 冷冻山羊肉、冷冻绵羊肉、冷冻牛肉 Frozen goat meat, Frozen mutton, Frozen beef | |
| 4 | 4000277 | BUMNOMIN | 3rd Bag, Ulaangom city, Uvs province, Mongolia | 屠宰、分割、储藏 Slaughter, Cutting, Storing | 冷冻山羊肉、冷冻绵羊肉、冷冻牛肉 Frozen goat meat, Frozen mutton, Frozen beef | |
| 5 | 3491404 | TES SHIM | Zur bag, Tes Soum, Zavkhan province | 屠宰、分割、储藏 Slaughter, Cutting, Storing | 冷冻山羊肉、冷冻绵羊肉、冷冻牛肉 Frozen goat meat, Frozen mutton, Frozen beef | |
| 6 | 5064376 | EDGS | Arts-Suuri, Niseg bagh, Tes soum, Zavkhan province, Mongolia | 屠宰、分割、储藏 Slaughter, Cutting, Storing | 冷冻山羊肉、冷冻绵羊肉、冷冻牛肉 Frozen goat meat, Frozen mutton, Frozen beef | |

<https://bit.ly/2LigYas>

ДеФакто ТОЙМ

Энэ том нутгийн дэд бүтэц, ложистикийг ченжүүд зохицуулаад ашиг хийгээд зарж байгаа болохоос биш хамаг мөнгийг нь аваад байгаа хүмүүс гэж ойлгох нь учир дутагдалтай. Тэгэхээр сайдтайгаа хариуцлага тооцохоос өмнө ложистикийн асуудлыг ярих ёстой. Хоёр хөршөө манай махыг аваач гэж 10-аад жил гуйсан. Нөгөөдүүл нь аваад эхлэхээр бид дотоодын хэрэгцээгээ хангахгүй байна, одоо гаргахгүй гэж хэлэх нь ямар вэ? Төрийн хийж чаддаг нэг арга нь мах хямдхан байхад нь аваад, үнэ нэмэгдсэн үед нь нөөцийн мах хэлбэрээр зардаг. Энэ арга нь урт хугацааны шийдэл ерөөсөө биш. Харин нөгөө арга нь шууд л экспортын татвараа нэмэх. Энэ арга нь худалдааны гэрээгээр хүлээсэн үүргээс хамаараад тийм ч амар биш л дээ.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.*

| 马肉生产企业 (9家) Horse meat products establishment(9) | | | | | | |
|---|------------------------|---|--|--|-------------------------------------|------------------------------------|
| 序号 NO. | 注册号 Approval NO. | 企业名称 Estname | 企业地址 Est.Address | 生产方式 Activities | 注册品种* Products | 备注 Note |
| 1 | 23 | Dorjin Gobi Meat Processing Factory | Sukhbaatar city, Selenge Province | 屠宰、分割 Slaughter, cutting | 冷冻分割马肉 Frozen cutting horse meat | 自2018年01月09日起(以启运日期为准)暂停该企业的在蒙注册资格 |
| 2 | 18 | Mongol Meat Expo Co., Ltd. | 20th Khoroo, Songinokhairkhan Distric, Ulaanbaatar | 屠宰、分割 Slaughter, cutting | 冷冻分割马肉 Frozen cutting horse meat | |
| 3 | 5342074 | Mon-Tuva factory of Green Grassland LLC in Uvs Province | Ulaangom city, Uvs Province Mongolia | 屠宰、分割、冷藏 Slaughter, cutting, cold Store | 冷冻分割马肉 Frozen cutting horse meat | |
| 4 | 2720752 | KhanKhans | Songinokhairkhan district, 29 th khoroo, peace avenue, KhanKhans building, Ulaanbaatar City | 马肉加工 processing | 生马肉包子、饺子** Horse meat dumpling | |
| 5 | 5470099 | Mongol eco meat | Songinokhairkhan district, 32 th khoroo, NO.111, Ulaanbaatar | 屠宰、分割 Slaughter, cutting | 冷冻分割马肉 Frozen cutting horse meat | |
| 6 | 4252284 | Darshan meat food | 15thbagha, Industrial district, Darkharsuum, Darkhan/Uul | 屠宰、分割 Slaughter, cutting | 冷冻分割马肉 Frozen cutting horse meat | |
| 7 | 2845008 | Sayan Uul | Songinokhairkhan district, 32-khoroo, 18-40street 51-1, Ulaanbaatar city, Mongolia | 屠宰、分割、冷藏 Slaughter, cutting, cold Store | 冷冻分割马肉 Frozen cutting horse meat | |
| 8 | 2069229 | Makh Impex | St.kharschid, 4th khoroo songinokhairhan district ulanbaatar city | 屠宰、分割、冷藏 Slaughter, cutting, cold store | 冷冻分割马肉 Frozen cutting horse meat | 自2017年9月13日获得注册资格 |
| 9 | 3491404 | TES-SHIM | Zar bag, Tes Soom Zavkhan province, Mongolia | 屠宰、分割、冷藏 Slaughter, cutting, cold Store | 冷冻分割马肉 Frozen cutting horse meat | 自2018年1月30日获得注册资格 |

<https://bit.ly/2LigYas>

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

☎ +976 94109342

🌐 www.defacto.mn

www.jargaldefacto.com

 **WORLD WINE**
Prosecco Bar



1 давхар, БУДДА виста
Утас: 7777-4747